



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар Б/80

Жавхлант

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.8, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.2.2 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн эзэнгүй нохой устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Отгонбаяр

Жавхлант багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Г.Шижирбаатар

Тархвар зүйч

Гишүүдэд:

М.Балдан

Жолооч

2. Эзэнгүй нохой устгах ажлыг зохион байгуулан, ажиллагсадтай гэрээ байгуулж хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч гарын үсгээр баталгаажуулан ажиллахыг багийн Засаг дарга (С.Отгонбаяр), ариутгал халдваргүйжүүлэлтийг хууль, журмын дагуу хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Г.Шижирбаатар) нарт үүрэг болгосугай.

3. Нохой устгах ажилд зарцуулагдах 750000 (Долоон зуун тавин мянган) төгрөгийг "Тохилог орчин ногоон хөгжил" дэд хөтөлбөрөөс холбогдох хууль, журмын дагуу зарцуулахыг Нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Г.Энхзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТЧУЛУУН